



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/97

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих "Хан алтайн ноён оргил" ХХК-ийн гүйцэтгэсэн Архивын тасгийн нягтруулсан шүүгээ ШХА-ТТ2023/45 ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ганхуяг (Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга)

Гишүүд: Л.Батгэрэл (Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Түмэнжаргал (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

Г.Сүхболд ("Хан алтайн ноён оргил" ХХК-ийн захирал)

Нарийн бичгийн дарга: С.Батдорж (Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

2. Тус ажлыг захиалагчаас баталсан ажлын даалгаврын дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Ганхуяг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Х.БАТБОЛД

8400001 Зах А/97 Ба